



## МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Монгол Улсын Засгийн Газраас харилцаа холбоо, мэдээллийн технологийг нийгэм, эдийн засгийн тэргүүлэгч салбарын нэгээр тодорхойлсноор “Цахим Үндэстэн” болох хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэхээр дэвшүүлж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүйн шинэчлэлт өөрчлөлтийг хийснээр 2022 оноос Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг шинээр байгуулан ажиллаж эхэлсэн, салбарын хууль эрхзүйн ялангуяа цахим орчин, кибер, мэдээллийн аюулгүй байдал, зөвшөөрлийн хуулийн орчин шинэчлэгдсэн онцлог жил байлаа.

Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (цаашид ХХЗХ гэх) нь УИХ-аар баталсан хууль, тогтоомжуудад заасан өөрийн бүрэн эрх, чиг үүргийг болон Засгийн газрын 2016 оны 256 дугаар тогтоолоор баталсан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм; 2020 оны 65 тоот тогтоолоор дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт; **“Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023-2025 оны үйл ажиллагааны стратеги”**; Хорооны 2022 оны 67 дугаар тогтоолоор баталсан **“Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”**-ний зорилт, заалтуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү стратеги, зорилго зорилт, төлөвлөлтийг хэрэгжүүлэх хүрээнд хууль эрх зүйн хэрэгжилтийг зөв, зохистой аргаар түргэн шуурхай хангуулахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай гол нөөцийг үр ашигтай удирдах, төлөвлөлтийг оновчтой болгох, гүйцэтгэлийн үнэлгээний системийг сайжруулах зэрэг Зохицуулах хорооны дотоод хэрэгцээ, шаардлагыг хангахад чухал ач холбогдолтой алхам болсон ба жил бүр системтэйгээр төлөвлөж, оролцогч талуудын харилцаа, хүний болон бусад шаардлагатай нөөцийг стратеги суурьтай удирдаж, жил бүрийн гүйцэтгэлийг бодитой тайлагнаж ажилласан болно.

УИХ-аас Харилцаа холбооны тухай хууль болон салбарын бусад<sup>1</sup> хуулиудад 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлт орсон, Цахим хөгжлийн багц хуулиуд (Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль), 2023 оноос Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотой Харилцаа холбооны зохицуулах хороо нь дараах бүрэн эрх, чиг үүргийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан бүрэн эрх;

<sup>1</sup> Радио долгионы тухай хууль, Шуудангийн тухай хууль



2. Радио долгионы асуудлаарх Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх<sup>2</sup>;
3. Харилцаа холбооны салбарт мөрдөгдөх норматив баримт бичгийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих<sup>3</sup>;
4. Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
5. Домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдсон журам батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
6. Тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам батлах;
7. Дотоодын хэрэглээний холбооны сүлжээнд зохицуулалт хийх журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;
8. Зохицуулах хорооны төсөв, ажлын албаны жилийн төлөвлөгөөг батлах<sup>4</sup>;
9. Шуудангийн харилцан холболтын журмыг баталж, хэрэгжилтийг хангуулах<sup>5</sup>;
10. Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх;
11. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн талаар хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх<sup>6</sup>;

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар Харилцаа холбооны зохицуулах хороонд мэдээллийн хэрэгсэл болсон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт хяналт тавих, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах чиг үүрэг хүлээлгэсэн болно. Харилцаа холбооны зохицуулах хорооны хувьд Монгол улсад ардчиллын үнэт зүйл болсон үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, олон талт мэдээ, мэдээлэл авах иргэний эрхийг хүндэтгэх хуулийн зорилт, зарчмын хүрээнд өргөн нэвтрүүлгийг хараат бус байлгах, даяаршлын эрин үед Монгол улсын үндэсний болон нийтийн нийтлэх эрх ашгийг радио, телевизийн салбарт хамгаалах зорилт тулгарч байна.

Мэдээлэл холбооны шугам, сүлжээтэй холбоотойгоор Барилгын тухай хууль, Газрын багц хуулийн төсөлд 3, Орон сууцны ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 8, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хуулийн төсөлд 27 саналыг тус тус хүргүүлсэн. Хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн үндэсний хороо байгуулсантай холбоотойгоор салбар хоорондын уялдааг хангах уг үндэсний хорооны төлөвлөгөө болон үндэсний хороогоор хэлэлцэх асуудлын төсөлд 7 санал боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн болно.

Харилцаа холбооны зах зээлийн нөхцөл байдал, харилцагчийн сэтгэл ханамж, хууль эрхзүйн ба бодлогын шинэ орчин, технологийн хурдацтай өөрчлөлт үйл ажиллагааг тодорхойлох, мэдэрч ажиллах зохицуулагч нарын зорилт байсаар ирсэн бөгөөд үйл ажиллагаагаа илүү мэргэжлийн, технологийн болон бодлогын хөгжилд нийцсэн, үр ашигтай байлгаж, хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн

<sup>2</sup> Радио долгионы тухай хуулийн 5.1

<sup>3</sup> Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3

<sup>4</sup> Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.16

<sup>5</sup> Шуудангийн тухай хуулийн 9.1.5

<sup>6</sup> Цахим гарын үсгийн тухай хуулийн 32.1



хэрэгжүүлэхэд эдгээр орчны өөрчлөлт, нөлөөллийг зөв, хурдтай мэдэрч, судалгаанд суурилсан, оновчтой зохицуулалтыг үр ашигтай хэрэгжүүлэх нь нэн чухал зорилт болж байгаа юм.

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо нь Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дах заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолоор баталсан, Засгийн газрын 2020 оны 65 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4.3.2 дах заалтыг тус тус үндэслэн "Харилцаа холбооны зохицуулах хорооны тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, ирэх 2 жилийн төсвийн төсөөлөл"-ийн төслийг тус тус хуралдаанаар хэлэлцэж, Хорооны хуралдааны тогтоол, тогтоолын хавсралтаар тус тус батлан хэрэгжүүлдэг бие даасан зохицуулах байгууллага юм.

ХХЗХ-ны жил бүрийн "Үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилт болон үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг тус тус гарган ЗГХЭГ-т хүргүүлэн Монгол Улсын Ерөнхий сайдад хэрэгжилтийг шууд тайлагнаж ажилладаг болно. Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, 2022 оны 203 дугаар "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж, байгууллагын орлого зардлын төлөвлөгөөнд хяналт тавин хэрэгжүүлдэг.

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос 2023 оны тайлант хугацаанд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, ХХЗХ-ны 2022 оны 67 тоот тогтоолын хавсралтаар баталсан **"Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого зардлын төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн төлөвлөгөө, байгууллагын 2024-2025 оны төсвийн төсөөлөл"**-д заасан зорилт, арга хэмжээ, төлөвлөгөөт ажил болон удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгавар, бусад ажлын хүрээнд арга хэмжээ (зохицуулалтын баримт бичиг, техникийн болон зохицуулалтын нөхцөл шаардлага, өргөн нэвтрүүлэг, давтамжийн хуваарилалт, ашиглалт, төлбөрийн хэмжээ, төсөл хөтөлбөр)-ний талаар Даргын зөвлөл, Хорооны хуралдаанаар тус тус хэлэлцэн шийдвэрлэж ажилласан.

ХХЗХ-ны хуралдаанаар баталсан "Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд заасан 3 бүлэг бүхий стратегийн зорилтын хүрээнд 84 бүтээгдэхүүн, зорилт заалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн баталж, хорооны ажлын алба, бүтцийн нэгж 11 субъектээс 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан бүтээгдэхүүн, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж хэрэгжүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн "Орон тооны бус гишүүн томилох тухай" 12 тоот захирамжаар Харилцаа холбооны тухай хуулийн 8.3, 8.4-т заасныг тус тус үндэслэн Алтай овогтой Лувсан-Очирыг Харилцаа холбооны зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр 6 жилийн хугацаагаар; Ерөнхий Сайдын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн "Орон тооны бус гишүүн томилох тухай" 30 тоот захирамжаар Чулуунцэцэг овогтой



Золбаярыг Харилцаа холбооны зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр 6 жилийн хугацаагаар; Ерөнхий Сайдын 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн "Орон тооны бус гишүүн томилох тухай" 36 тоот захирамжаар Нямдалай овогтой Мандахбаатарыг Харилцаа холбооны зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр 2 жилийн хугацаагаар тус тус томилсон болно.

УИХ-аас Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн тус хорооноос 2022-2023 онд салбарын зохицуулалтын холбогдох баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж ажилласан.

Тайлангийн хугацаанд буюу 2023 оны эцсийн байдлаар, ХХЗХ-ны 2023 оны ээлжит 16 удаа, ээлжит бус 6 удаагийн хуралдааныг тус тус зохион байгуулж, эдгээр хуралдаанаар нийтдээ 130 гаруй асуудлыг хэлэлцэн 89 цаг хуралдаж, зохицуулах хорооны хуралдаанаас баталсан 177 тогтоол шийдвэр болон 8 удаагийн хуралдааны тэмдэглэлийг батлан шийдвэрлэсэн. Хуралдааны тогтоол шийдвэрийн нэгдсэн жагсаалтыг тайлангийн хавсралт-2-т нэгтгэн үзүүлэв. (2023 оны тогтоол, шийдвэрийг нэгтгэн үзүүлбэл):

- Зохицуулах хорооны үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрхзүйн хэм хэмжээний акт буюу зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлага, давтамжийн хуваарилалт ба төлөвлөлтийн баримт бичиг 40 гаруй байгаа бөгөөд ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд 11 баримт бичгийн нэмэлт, өөрчлөлт оруулсан болон 2 тогтоолын хасалтыг хянуулан хөдөлгөөн хийлгэсэн;
- Захиргааны ерөнхий хууль, УИХ-аас 2019 онд Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуульд тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлт, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлын багц хуулиудад тус тус нийцүүлэн зохицуулалтын баримт бичгийг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр тогтоож баталсан 19;
- Зохицуулалтын баримт бичиг, давтамжийн хуваарилалт, харилцан холболт, шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх, зохицуулалтын үйлчилгээний хөлс, төлбөрийн хэмжээ, техникийн нөхцөл шаардлага, дугаарлалт, дүрэм журмыг ХЗДХЯ-нд нийтээр даган мөрдөх хэм хэмжээнд хянуулан бүртгүүлэхээр албан тоотоор хүргүүлсэн ба ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд 19 баримт бичиг, үнэ тарифыг тогтоож зохих хууль тогтоомжийн дагуу хүргүүлэн хянуулж шинээр бүртгүүлсэн болно.
- Шинээр болон шинэчлэн, нэгтгэн боловсруулж батлуулсан (техникийн нөхцөл шаардлага, өргөн нэвтрүүлэг, давтамжийн хуваарилалт, баталгаажуулалт, зөвлөмж, үнэ тариф тогтоох)-8;
- Тогтоолын хавсралт болон тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан-5;
- Захиргааны ерөнхий хууль, УИХ-аас 2019 оны 5 сард Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуульд тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу шинээр баталсан, шинэчилсэн, өөрчлөлт оруулсантай



холбогдуулан хүчингүй болгосон-19 тогтоол, хавсралт баримт бичиг зэрэг болно.

Хорооны дарга, Ажлын албаны даргаас өгсөн үүрэг, чиглэл болон 7 хоног бүрийн шуурхай зөвлөгөөн, ДЗХ-ны үүрэг даалгаврыг тухай бүр биелэлтийг гаргаж, тайлагнан ажилласан болно. ХХЗХ-ны хуралдааны 2023 оны 1 дүгээр, 2 дугаар, 3 дугаар, 4 дүгээр улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг холбогдох бүтцийн нэгжээс авч нэгтгэж эдгээр төлөвлөгөөг Хорооны даргаар 2023 оны тухай бүр тус тус батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг сар бүр дүгнэн тайлагнав.

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны 2023 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн тухай болон "Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны 2022-оны тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан"-г тус тус хэлэлцүүлэн тайлагнаж ажилласан болно.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны 28 тоот тогтоолын хавсралтаар баталж, 2021 оны 19 дүгээр тогтоол, 2022 оны 62 тоот тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан "ХХЗХ-ны хуралдааны дэг"-ийн талаар танилцуулга, нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж, энэхүү баримт бичгийн хууль эрх зүй, дүрэм журмын нийцэл, давхардал, уялдаа холбоог хянаж үзэх, процедурын шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулан ажилласан. Ажлын хэсгээс Зохицуулах хорооны 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит 09 дүгээр хуралдаанд "Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг"-ийг шинэчлэн батлах тухай танилцуулга, тогтоолын төсөл, тогтоолын хавсралт бичгийн төсөл, саналын товчоог эцэслэн боловсруулан хэлэлцүүлсэн ба Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4 дүгээр зүйлийг үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 93 тоот "Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг"-ийг шинэчлэн батлах тухай тогтоолыг хавсралтын хамт баталж, тогтоолыг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж эхэлсэн.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 04 дүгээр хуралдаанд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Төсвийн тухай хуулийн 8.9.8 заалт болон Хорооны даргаас өгсөн удирдамж, чиглэлийн хүрээнд ЗУХАГ болон Дотоод хяналт, аудитын албанаас нэгтгэн боловсруулсан Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, Хорооны 2022 оны хуралдааны тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон Байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд УАГ-ын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 07/560 тоот албан бичгээр ирүүлсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн тухай асуудлыг хэлэлцсэн. Хуралдаанаас хорооны дарга, гишүүдээс өгсөн удирдамж, чиглэлийн дагуу Зохицуулах хорооны 2022 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан материаллаг алдаагүй, НББ-ийн тухай хууль, СТОУС-д



нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” бүхий санхүүгийн тайлангийн аудитын гэрчилгээ, зөвлөмжийг хүлээн авч, ҮАГ-ын ирүүлсэн дүгнэлт зөвлөмжүүдийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Үндэсний Аудитын Газар болон ЗГХЭГ-т тус тус хүргүүлэн тайлагнасан.

Зохицуулах хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4-т заасны дагуу олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх саналыг хянан үзэж, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө буюу 2023 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс өмнө батлах чиг үүрэгтэй. Энэ ажлын хүрээнд Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээс сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь цагийн саналыг хуульд заасан хугацаанд хүлээн авч, хууль, журамд нийцүүлэн хянах ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуулийн сурталчилгааг төлбөргүй нэвтрүүлэх хуваарь, цагийн саналыг хянаж үзээд, боловсруулсан холбогдох танилцуулга, тогтоолын төсөл, хавсралт хуваарь, цагийн хуваарийн төслийг тус тус хэлэлцээд, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2, 45.4 дэх хэсгүүдийг үндэслэн “Олон нийтийн радио, телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цаг батлах тухай” 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 47 тоот тогтоолыг хавсралтын хамт батлав. Сонгуулийн ерөнхий хороо, Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз, нөхөн сонгуульд нэр дэвшигч нам, эвсэлд албан тоотоор хүргүүлж, цахим хуудаст байршуулан хэрэгжилтэд хяналт тавьж, хамтран ажилласан.

ХХЗХ-ны ажлын албанаас 2023 онд мэдээлэл харилцаа холбоо, шуудангийн салбарын зохицуулалтын чиглэлээр одоо хүчин төгөлдөр мөрдөж буй зохицуулалтын баримт бичиг болох дүрэм журам, нөхцөл шаардлага, техникийн нөхцөл, төлбөрийн хэмжээ, зохицуулалтын үйлчилгээний хэмжээ тогтоох, давтамжийн зохицуулалт, хуваарилалтын баримт бичгийн эрх зүйн актад дүн шинжилгээ, мониторинг хийснээр Захиргааны ерөнхий хууль, хууль тогтоомжид нийцүүлэн 30 гаруй зохицуулалтын баримт бичгүүдийг ХХЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэв.

ХДЗХЯ-наас ирүүлсэн ХХЗХ-ноос захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлсэн, бусад баталсан тогтоол шийдвэрийн талаар судалгааг ирүүлсэн загварын дагуу нэгтгэн боловсруулж, Даргын 2023 оны 05 дугаар сар, 10 дугаар сард албан тоотоор хүргүүлэв.

Захиргааны ерөнхий хуулийн дагуу ХЗХДЯ-аар хянуулан бүртгүүлсэн, өөрчлөлт хөдөлгөөн хийсэн, хасуулсан 23 хорооны тогтоолыг хавсралтын хамт Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем ([www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)), хорооны цахим хуудас



(www.csc.gov.mn)-д тус тус байршуулан ажилласан (Хавсралт-2: Дэлгэрэнгүй судалгаа). Үүнд:

- Хорооны 2023 оны 01 тоот тогтоол: Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №5060: Хорооны 2021 оны 02 тоот тогтоол);
- Хорооны 2023 оны 01 тоот тогтоол: Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай (ХЗДХЯ №4904: Хорооны 2020 оны 64 тоот тогтоол);
- Хорооны 2023 оны 14 тоот тогтоол: "Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-д өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №4970: Хорооны 2020 оны 88 тоот тогтоол);
- Хорооны 2023 оны 15 тоот тогтоол: "Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-д өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №5305: 2021 оны 23 тоот тогтоол);
- Хорооны 2023 оны 16 тоот тогтоол: "Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-д өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №5306: Хорооны 2021 оны 24 тоот тогтоол);
- Хорооны 2023 оны 22 тоот тогтоол: "Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлага" батлах тухай /Шуудангийн сүлжээ байгуулах/;
- Хорооны 2023 оны 23 тоот тогтоол: "Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг батлах тухай (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №6194);
- Хорооны 2023 оны 24 тоот тогтоол: "Шуудангийн харилцан холболтын журам"-д өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №4696: Хорооны 2019 оны 54 тоот тогтоол);
- Хорооны 2023 оны 30 тоот тогтоол: "Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №5306: Хорооны 2021 оны 74 тоот тогтоол);
- Хорооны 2023 оны 30 тоот тогтоол: "Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №5306: Хорооны 2021 оны 74 тоот тогтоол);
- Хорооны 2023 оны 51 тоот тогтоол: "Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №4971: Хорооны 2020 оны 89 тоот тогтоол);
- Хорооны 2023 оны 57 тоот тогтоол: Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох тухай (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №6270);
- "Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ыг шинэчлэн батлах тухай (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №6341);
- "Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ыг шинэчлэн батлах тухай (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №6342);
- "Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №5949: Хорооны 2022 оны 38 тоот тогтоол);
- "Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-г шинэчлэн батлах тухай (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №6385);
- "Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг шинэчлэн батлах тухай (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №6451);



- “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №6452);
- Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасаж, актлах саналын тухай (2023 оны 17 тоот тогтоол);
- Олон нийтийн радио, телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цаг батлах тухай (2023 оны 47 тоот тогтоол);
- Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023 оны 107 тоот тогтоол (Хорооны 2022 оны 67 тоот тогтоол: “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө, зардал 2024-2025 оны төсвийн төсөөлөл”-ийг батлах тухай);
- Үндсэн хөрөнгө дахин үнэлэх саналын тухай (2023 оны 74 тоот тогтоол);
- “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, 2025-2026 оны төсвийн төсөөлөл”-ийг батлах тухай (2023 оны 155 тоот тогтоол) зэрэг 55 тогтоолыг батлан хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан болно.

Тайлангийн хугацаанд, ХХЗХ-ны 2023 оны тогтоол, тогтоолын хавсралтаар Үйлчилгээний тариф батлах тухай (Юнивишн ХХК), Үйлчилгээний тариф батлах тухай (ДДЭШ ТВ ХК), Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасаж, актлах саналын тухай, Олон нийтийн радио, телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цаг батлах тухай тогтоолыг батлан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.5-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшлийн мэдээллийг маягтын дагуу хүлээн авч эмхэтгэн хорооны вэб хуудсанд (<https://crc.gov.mn/k/4x/9B>) байршуулсан.

Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ, баталгаажуулалтын тохирлын гэрчилгээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах хүрээнд шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ажлын байрны үзлэг хийж аж ахуйн нэгжид холбогдох хууль, дүрэм, журам, нөхцөл, шаардлагын талаар утсаар, уулзалтаар, цахим шуудангаар 150 гаруй аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Хэт богино долгионы ФМ радиогийн сүлжээ, үйлчилгээний хүртээмж (газар нутгаар), үйлчилгээний нөхцөл байдал, үйлчилгээний чанарын байдлын талаар судалгаа, мэдээлэл гаргах ажлын хүрээнд радиогийн үйлчилгээний хүртээмж, зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын талаарх судалгааг гүйцэтгэж тус хорооны вэб хуудсанд (<https://crc.gov.mn/l/23/0/6B>) байршуулан олон нийтэд мэдээлэн ажиллав.

2023 оны эцсийн байдлаар, Хорооны 2023 оны хуралдааны тогтоолоор шинэчлэн баталсан, шинээр баталсан, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрэм, журам, техникийн болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, өрсөлдөөний журам, үнэ тариф төлбөрийн хэмжээ, радио давтамжийн зохицуулалт, хуваарилалт зэрэг зохицуулалтын баримт бичгийг ХЗДХЯ-нд хянуулан бүртгүүлж шийдвэрлэсэнтэй холбогдуулан тус хорооны ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон Хорооны



2020 оны 64 тоот тогтоол) шийдвэрийн 4904 тоот улсын бүртгэлээс 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр хассан, 2019 оны 52 тоот тогтоол, 2019 оны 53 тоот тогтоол, 2022 оны 59 тоот тогтоол, 2017 оны 32 тоот тогтоол, 2017 оны 31 тоот тогтоол, 2018 оны 18 тоот тогтоол, 2019 оны 09 тоот тогтоол, 2020 оны 70 дугаар тогтоол, 2019 оны 28 тоот тогтоол, 2021 оны 19 тоот тогтоол, 2022 оны 62 тоот тогтоол, 2020 оны 71 тоот тогтоол, 2021 оны 51 тоот тогтоол, 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 2018 оны 23 дугаар тогтоол, 2020 оны 24 дүгээр тогтоол, 2018 оны 23 дугаар тогтоол, 2020 оны 24 дүгээр тогтоол зэрэг нийт 19 тогтоолыг тус тус хүчингүй болгов.

Хорооны 2023 оны ээлжит, ээлжит бус 22 удаагийн хуралдааны мэдээний төслийг боловсруулж, баталсан тогтоол шийдвэр, тэмдэглэлийг албажуулах, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан бүртгүүлсэн 2022 оны 2 тогтоол, 2023 оны 19 тогтоолыг хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем ([www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)), хорооны цахим хуудас ([www.cgc.gov.mn](http://www.cgc.gov.mn))-д тус тус байршуулан олон нийт, хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт ил тод, нээлттэй, цахимаар авах боломжийг бүрдүүлэв.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 12 дугаар хуралдаанаар хорооны 2023 оны 107 тоот тогтоолыг баталж, Хорооны 2022 оны 67 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө, зардал 2024-2025 оны төсвийн төсөөлөл”-ийг батлах тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлтийг оруулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

2023 оны жилийн эцсийн байдлаар, ХХЗХ-ны хуралдаанаар холбогдох газар, хэлтсийн үнэлгээ, дүгнэлт болон сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлт, саналыг болон ЗУХАГ-ын санал дүгнэлтийг тус тус үндэслэн тусгай зөвшөөрөл, тусгай дугаарын зөвшөөрлийн асуудлаар хорооны нийт 122 тогтоолыг батлан шийдвэрлэсэн. Үүнд: Хорооны хуралдааны тогтоолоор нийтдээ 92 хуулийн этгээдэд 97 тусгай зөвшөөрөл болон харилцаа холбооны сүлжээний дугаар шинээр олгосон; 128 хуулийн этгээдийн 154 тусгай зөвшөөрөл болон харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглах хугацааг сунгасан; 48 хуулийн этгээдийн 60 тусгай зөвшөөрлийг сэргээсэн; 13 хуулийн этгээдийн 19 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан; 54 хуулийн этгээдийн 74 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн; 3 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрөл, нэрийг шилжүүлсэн; 69 хуулийн этгээдийн 83 тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгон шийдвэрлэжээ. Тусгай зөвшөөрлийн талаар баталсан 122 тогтоол, шийдвэрийг албажуулан холбогдох иргэн, хуулийн этгээд нарт 320 гаруй албан тоотоор хүргүүлэн мэдэгдэж, ЗУХАГ-тай зөвшөөрлийн гэрээг шинээр байгуулах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хугацаа сунгах, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон талаар байгууллагын цахим мэдээллийн санд тухай бүр өөрчлөлт тодотгол тус тус оруулан ажилласан.

ХХЗХ-ны ажлын албаны үйл ажиллагаа, үйл ажиллагааны болон төсөв, санхүүгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт, байгууллагын



өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, ажлын хэсэг томилон ажиллуулах, хүний нөөц, хөдөлмөрийн харилцааг зохицуулах, Даргын зөвлөл, гадаад хамтын ажиллагааны хүрээнд 2023 онд Хорооны Даргын А-тушаал 358, Б-тушаал 114 тус тус батлан шийдвэрлэж, тушаалын хэрэгжилтийг хангуулан тайлагнаж ажиллав.

Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ, баталгаажуулалтын тохирлын гэрчилгээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах хүрээнд шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ажлын байрны үзлэг хийж аж ахуйн нэгжид холбогдох хууль, дүрэм, журам, нөхцөл, шаардлагын талаар 120 гаруй, утсаар, уулзалтаар, цахим шуудангаар нийтдээ 150 гаруй иргэн, аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Тухайлбал, Радио давтамжийн харилцан нөлөөллийн хэмжилт томилолтоор 2023 онд аймаг орон нутагт 39 байршилд, Улаанбаатар хотод 66 байршилд харилцан нөлөөллийн хүсэлт, гомдлыг шалгаж тус тус шийдвэрлэв. Цахилгаан соронзон орны хүний биед нөлөөлөх нөлөөллийн хэмжилт дүгнэлтийг ирүүлсэн хүсэлт, гомдлын дагуу Улаанбаатар хот, орон нутагт газар дээр нь очиж ажиллан 39 удаагийн хэмжилтийн дүгнэлт, зөвлөмжийг гаргаж, хүргүүлэн хяналт тавьж ажилласан.

Тайлант хугацаанд, ХХЗХ-ноос радио давтамж ашиглах эрхийн бичгийн хүсэлт санал, ирүүлснээс нийт 207 дүгнэлтийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд боловсруулж, радио давтамж ашиглах эрхийн бичгийг хуулийн этгээд нарт шинээр 155, сунгалтаар 78, өөрчлөлт оруулахаар 27, цуцлах 7 эрхийн бичгийн асуудлыг тус тус Хорооны даргын тушаалаар шийдвэрлэв.

Радио долгионы хяналтын үйл ажиллагаанд "MNS ISO/IEC 17020:2013–тохирлын үнэлгээ, хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага" стандартыг баримтлан Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төвд итгэмжлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын тохирлын гэрчилгээ шинээр авах, сунгахаар ирүүлсэн нийт 527 иргэн, хуулийн этгээдийн материал хүсэлтэд хуулийн дагуу үнэлгээ хийж, дүгнэлтийг боловсруулан Хорооны даргын тушаалаар баталгаажуулалтын тохирлын гэрчилгээ шинээр 278, хугацааг сунгахаар 249 тус тус шийдвэрлэн олгосон байна.

Байгууллагын цахим хуудас, мэдээллийн санд 2023 онд шинээр баталсан 177 тогтоол шийдвэр, ХЗДХЯ-нд шинээр бүртгүүлсэн, хөдөлгөөн хийлгэсэн, хасуулсан нийт 38 тогтоол болон хорооны хуралдааны тогтоолоор хүчингүй болгосон, шинэчлэн баталсан, нэмэлт өөрчлөлтийн жагсаалт, мэдээллийг ЗУХАГ-тай хамтран шинэчлэх арга хэмжээг авлаа.

Тайлангийн хугацаанд буюу 2023 оны эцсийн байдлаар, ХХЗХ-ны 2023 оны ээлжит 16 удаа, ээлжит бус 6 удаагийн хуралдааны шийдвэрийг хуралдаан тус бүрээр тоймлон үзүүлбэл:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар /2023-01-31/ "Зөвшөөрлийн тухай" хуультай нийцүүлэн Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын баримт бичгүүдэд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох багц арга хэмжээний тухай (Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн



- нөхцөл, шаардлага"; Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"; Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"; "Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"; "Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам" хүчингүй болгох тухай); "Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн үйл үйл ажиллагаанд хийсэн шалгалт"-ын тайлан (Танилцуулга); Давамгай байдалтай үйлчилгээ эрхлэгч ДДэш ТВ ХХК-ийн үндсэн үйлчилгээний тариф батлах тухай; Давамгай байдалтай үйлчилгээ эрхлэгч Юнивишн ХХК-ийн үндсэн үйлчилгээний тариф батлах тухай (Хорооны 2022 оны 13 дугаар Тэмдэглэл); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сунгах, өөрчлөлт оруулах, сэргээх, хүчингүй болгох тухай; Орон нутгийн нэр бүхий телевизийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай) зэрэг асуудлыг хэлэлцэн нийт хорооны 16 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 2 тэмдэглэлээр баталсан тогтоолыг хэрэгжүүлэх хугацаатай удирдамж, чиглэлийн холбогдох бүтцийн нэгжид үүрэг болгон даалгав.
2. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 02 дугаар хуралдаанаар /2023-02-17/ ХХЗХ-ны эд хөрөнгийн 2022 оны тооллогын тайлан, хөрөнгө актлах саналын тухай; Хорооны хуралдааны 2022 оны 03 дугаар Тэмдэглэлийн хэрэгжилтийн талаар танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай) зэрэг асуудлыг хэлэлцэн хорооны 5 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.
  3. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар /2023-02-28/ "Зөвшөөрлийн тухай" хуультай нийцүүлэн Шуудангийн зохицуулалтын зарим нөхцөл шаардлага, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах тухай багц асуудал (Үүнд: "Шуудангийн харилцан холболтын журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай-2019 оны 54 тоот тогтоол; "Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлага" /Шуудангийн сүлжээ байгуулах/ батлах тухай; "Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг батлах тухай); ХХЗХ-ны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дансны авлагад тохируулга хийх тухай; Бусад: "Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг"-ийн тухай зэрэг асуудлыг хэлэлцэн хорооны 3 тогтоол, 1 хуралдааны тэмдэглэлийг баталсан болно.
  4. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 01 дүгээр хуралдаанаар /2023-03-17/ "Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт"-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналын тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сэргээх, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай) тухай зэрэг асуудлыг хэлэлцэн хорооны хуралдааны 5 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.
  5. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 04 дугаар хуралдаанаар /2023-03-30/ Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2021 оны 74 тоот тогтоол); "ХХЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн 2022 оны үндсэн статистик, үзүүлэлтүүд"-ийн тухай танилцуулга; Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, Хорооны 2022 оны хуралдааны тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай) асуудлыг хэлэлцэн хорооны 5 тогтоолыг батлан шийдвэрлэв.
  6. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 05 дугаар хуралдаанаар /2023-04-21/ Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээл, өрсөлдөөний орчны үнэлгээ, судалгааны үр дүн, ХХЗХ-ноос 2023 онд нээлттэй шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоон батлах тухай (Хорооны 2022 оны 12 дугаар тэмдэглэлийн хэрэгжилт); ХЗДХЯ-ны санал, дүгнэлтийг хэрэгжүүлэх тухай (Хорооны 2023 оны 22 тоот тогтоол); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ



- шинээр олгох, сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг тус тус хэлэлцэн хорооны 6 тогтоолыг баталсан юм.
7. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 02 дугаар хуралдаанаар /2023-05-11/ ХХЗХ-ноос 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийн төлбөр тогтоосон тухай танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сунгах, сэргээх, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн хорооны хуралдааны 6 тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.
  8. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 03 дугаар хуралдаанаар /2023-05-26/ "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45.4-т заасны дагуу МҮОНРТ-ийн 2023 оны нөхөн сонгуулийн төлбөргүй сурталчилгаа нэвтрүүлэх хуваарь, цагийг батлах" тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай) асуудлыг хэлэлцээд, хорооны хуралдааны 4 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.
  9. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар /2023-05-31/ "Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2020 оны 89 тоот тогтоол); "Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний нөхцөл, шаардлага"-д өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2020 оны 05 тоот тогтоол); Радио давтамж ашиглан харилцаа холбооны үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээ эрхлэгч (яриа, дата, мессеж) нарын харилцан холболтын чиглэлээр батлагдсан зохицуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийн тухай танилцуулга; Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийг шийдвэрлэсэн тайлангийн танилцуулга (Хорооны 2022 оны жилийн эцэс, 2023 оны 1 дүгээр улирал); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, Дугаар ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай) асуудлыг тус тус хэлэлцэн зохицуулах хорооны 6 тогтоолыг баталж, хуралдааны 1 тэмдэглэлээр холбогдох ажлын хэсэгт удирдамж, чиглэл өгсөн болно.
  10. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 07 дугаар хуралдаанаар /2023-06-19/ Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, Дугаар ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай; Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай; Статистик тайлан мэдээг хугацаандаа ирүүлээгүй ААН-ийн ТЗ-ийг түдгэлзүүлэх тухай); Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл 2023 онд олгох нээлттэй сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, дүгнэлтийн тухай (Хорооны 2023 оны 35 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); 5G Дараа үеийн хөдөлгөөнт холбооны үндсэн ойлголт судалгааны тайлангийн танилцуулга болон 5G Дараа үеийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх хэрэгцээ судалгааны танилцуулга; ХХЗХ-ны шийдвэртэй холбоотой, одоо үргэлжилж буй шүүхийн маргааны талаарх мэдээлэл зэрэг 10 гаруй асуудлыг тус тус хэлэлцэн зохицуулах хорооны 15 тогтоолыг батлан шийдвэрлэв.
  11. Хорооны 2023 оны ээлжит 08 дугаар хуралдаанаар /2023-07-04/ "Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ыг шинэчлэн батлах тухай (Хорооны 2017 оны 32 тоот тогтоол); "Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ыг шинэчлэн батлах тухай (Хорооны 2017 оны 31 тоот тогтоол); "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын төслийн тухай танилцуулга; "Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-нд өөрчлөлт оруулах тухай



- танилцуулга; Харилцаа холбооны үйлчилгээ буюу интернэт, яриа, олон суваг дамжуулах болон интернэт протоколд суурилсан үйлчилгээний зах зээлийн нөхцөл байдлын судалгаа, дүгнэлтийн тухай; ХХЗХ-ны эд хөрөнгийг дахин үнэлэх ажлын хэсгийн тайлан, санал дүгнэлтийн тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт); "ХХЗХ-ны хуралдааны дэг"-ийг шинэчлэн батлах тухай танилцуулга; Бусад: Хорооны гишүүдэд ОНДО ХХК-иас ирүүлсэн албан бичгийн тухай танилцуулга (2023 оны 44 тоот тогтоолын тухай) зэрэг нийтдээ 10 гаруй асуудлыг тус тус хэлэлцэн зохицуулах хорооны 16 тогтоолыг баталсан болно.
12. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 09 дүгээр хуралдаанаар /2023-07-26/ "Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2022 оны 38 тоот тогтоол); "Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-нд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2020 оны 71 тоот тогтоол); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт); "ХХЗХ-ны хуралдааны дэг"-ийг шинэчлэн батлах тухай нийтдээ 6 асуудлыг тус тус хэлэлцэн зохицуулах хорооны 6 тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.
  13. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 10 дугаар хуралдаанаар /2023-08-09/ "Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-г шинэчлэн батлах тухай (Хорооны 2020 оны 71 тоот тогтоол); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг тус тус хэлэлцэн зохицуулах хорооны 4 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.
  14. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаар /2023-08-31/ Тариф шинэчлэн батлах тухай (Монгол шуудан ХК); Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2023 оны эхний хагас жилийн үндсэн үзүүлэлтийн тайлангийн танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, түдгэлзүүлэх тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, Дугаар ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт); Бусад: Хорооны дарга, гишүүдэд ОНДО ХХК-иас ирүүлсэн албан тоот, гомдлын талаар танилцуулга зэрэг асуудлыг тус тус хэлэлцэн зохицуулах хорооны 7 тогтоолыг батлан шийдвэрлэв.
  15. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 12 дугаар хуралдаанаар /2023-09-13/ "Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг шинэчлэн батлах тухай; "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ыг шинэчлэн батлах тухай; Харилцаа холбооны зохицуулах хорооны тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2022 оны 67 тоот тогтоол); "Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ" шинэчлэн батлагдсантай холбогдуулан тогтоолыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (Хорооны 2023 оны 94 тоот тогтоол); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, нэмэлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг тус тус хэлэлцэн хорооны 8 тогтоолыг баталж, хорооны 1 хуралдааны тэмдэглэлээр хугацаатай удирдамж чиглэлийг холбогдох ажлын албанд даалгахаар тогтов.
  16. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 13 дугаар хуралдаанаар /2023-09-28/ Радио давтамж ашиглан харилцаа холбооны үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээ эрхлэгч (яриа, дата, мессеж) нарын харилцан холболтын чиглэлээр батлагдсан зохицуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийн тухай танилцуулга (Хорооны 2023 оны 04 дүгээр хуралдааны



- тэмдэглэл); "Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах" төслийн явцын тухай танилцуулга; "Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт"-ын баримт бичгийн төслийн тухай; Телевиз, радиогийн хөтөлбөрт хийсэн мониторингийн тайлан (2023 оны эхний хагас жилийн байдлаар); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Хорооны тогтоолоор шинээр ТЗ олгосон боловч гэрчилгээ аваагүй, гэрээ байгуулаагүй зэрэг зөрчилтэй ААН-ын судалгаа, зөвшөөрлийг цуцлах санал дүгнэлтийн тухай; Харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг тус тус хэлэлцэж, зохицуулах хорооны 8 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.
17. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 04 дүгээр хуралдаанаар /2023-10-12/ Тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулах тухай (Үүнд: -Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Сэлэнгэ аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх; -Хэнтий аймагт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх; -Баянхонгор, Булган, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Увс, Хэнтий аймагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх; -Монгол Улсын нутаг дэвсгэрт олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх), Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт) тухай зэрэг асуудлыг хэлэлцэн хорооны хуралдааны 6 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.
18. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 14 дүгээр хуралдаанаар /2023-10-31/ "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг"-ийн төслийн тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг тус тус хэлэлцэж, зохицуулах хорооны 11 тогтоолыг батлан шийдвэрлэж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр хугацаатай удирдамж, чиглэлийг холбогдох ажлын хэсэгт өгөхөөр тогтов.
19. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 05 дүгээр хуралдаанаар /2023-11-10/ Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ-ийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглах хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) тухай асуудлыг хэлэлцэж, тус хорооны хуралдааны 4 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.
20. ХХЗХ-ны 2023 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар /2023-11-30/ "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг"-ийн төслийн тухай; "Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон орлого, зардлын төлөвлөгөө, байгууллагын 2025-2026 оны төсвийн төсөөлөл"-ийн тухай багц баримт бичгүүдийн төслийн анхны хэлэлцүүлэг (Үүнд: ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний төсөл; "ХХЗХ-ны 2024 оны орлогын төлөвлөгөө"-ний төсөл; "ХХЗХ-ны 2024 оны зардлын төлөвлөгөө"-ний төсөл; "ХХЗХ-ны 2024 оны хөрөнгө оруулалтын зардал"-ын төсөл; "ХХЗХ-ны 2024 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал"-ын төсөл; "ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны зардал"-ын төсөл; "ХХЗХ-ны 2025-2026 оны төсвийн төсөөлөл"-ийн төсөл); "Монгол Улсын харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө"-нд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын тухай танилцуулга (ЦХХХ-ны яаманд хүргүүлэх); Харилцаа холбооны сүлжээний зохицуулалт, өнөөгийн байдлын талаар танилцуулга; Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохоор зарласан нээлттэй сонгон шалгаруулалтын үнэлгээний хорооны санал, дүгнэлтийн тухай (Хорооны 2023 оны 35 тоот, 121 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); "Хэрэглэгчийн сонголтод нөлөөлж байгаа хүчин



зүйлс, харилцаа холбооны үйлчилгээний нээлттэй байдлын түвшинг тодорхойлох судалгаа"-ны танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлт); Бусад асуудал: "Монголын FM Радионуудын Нэгдсэн холбоо-ноос ирүүлсэн албан тоотын тухай асуудлыг тус тус хэлэлцэж, зохицуулах хорооны нийтдээ 11 тогтоолыг батлан шийдвэрлэв.

21. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 06 дүгээр хуралдаанаар /2023-12-06/ Домэйн нэрийн зохицуулалт, цаашид хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (Хуралдааны тэмдэглэлийн төсөл); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ-ийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) тухай зэрэг асуудлыг хэлэлцэн хорооны хуралдааны 6 тогтоолыг баталж, хуралдааны 1 тэмдэглэлээр холбогдох бүтцийн нэгжид удирдамж, чиглэл өгч шийдвэрлэсэн.
22. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 16 дугаар хуралдаанаар /2022-12-20/ "Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө болон зардал, байгууллагын 2025-2026 оны төсвийн төсөөлөл"-ийг (Үүнд: ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний төсөл; "ХХЗХ-ны 2024 оны орлогын төлөвлөгөө"-ний төсөл; "ХХЗХ-ны 2024 оны зардлын төлөвлөгөө"-ний төсөл; "ХХЗХ-ны 2024 оны хөрөнгө оруулалтын зардал"-ын төсөл; "ХХЗХ-ны 2024 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал"-ын төсөл; "ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны зардал"-ын төсөл; "ХХЗХ-ны 2025-2026 оны төсвийн төсөөлөл"-ийн төсөл) батлах тухай; "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг"-ийн төслийн тухай (Хорооны 2023 оны ээлжит 15 дугаар хуралдаанаас өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх: Тэмдэглэлийн төсөл); "Радио долгион өргөн нэвтрүүлгийн хяналтын төвийн 2023 оны үйл ажиллагааны тайлан" танилцуулга; "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт"-ын үнэлгээний хорооны санал, дүгнэлтийн тухай (Хорооны 2023 оны 113 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, нэмэлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг 5 үндсэн багц асуудлыг тус тус хэлэлцэж, зохицуулах хорооны нийтдээ 23 тогтоолыг баталж, 1 хуралдааны тэмдэглэлээр хугацаатай үүрэг даалгаврыг холбогдох ажлын хэсэгт өгсөн болно.

Хорооны 2023 оны ээлжит 02 дугаар хуралдаанаар ажлын хэсэг, ЗУХАГ-ын Санхүүгийн хэлтсээс боловсруулсан 2022 оны тооллогын үр дүн, үндсэн хөрөнгө ашиглалтаас хасаж, актлах саналын тухай танилцуулга, тогтоолын төсөл, хавсралт жагсаалтын төслийг тус тус хэлэлцэн шийдвэрлэв. Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4.3.3 заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам", байгууллагын 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийг тоолсон ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 17 тоот "Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасаж, актлах саналын тухай" тогтоолыг нэр бүхий эд хөрөнгө, тоног төхөөрөмж, программ хангамж, автомашин бүхий 4 хавсралт жагсаалтын хамт



батлав. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, зөвшөөрлийг актлан авч шийдвэрлэсэн.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар, ХХЗХ-ны батлагдсан орлого, зарлагын болон үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзэхэд байгууллагын тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлс, эрхийн төлбөр, радио давтамжийн ашиглалт үйлчилгээний төлбөр, бусад орлогоос нийт 10,310.070 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагаанд гүйцэтгэлээр 8,922.700 сая төгрөгийн зардлыг гүйцэтгэлээр зарцуулан ажилласан болно. Энэ нь ХХЗХ-ны 2022 оны 67 тоот тогтоолын хавсралтаар баталсан 2023 оны орлогын төлөвлөгөөний бүрдүүлэлт 113.7 хувь, зардлын гүйцэтгэл 74.58 хувь тус тус гүйцэтгэлтэй ажилласан байна.

Зохицуулах хорооны хуралдаан ээлжит, ээлжит бус 22 удаагийн хуралдааныг зохион байгуулж, хуралдааны үйл ажиллагааны зардалд гүйцэтгэлээр нийт 292.24 сая төгрөгийг (гүйцэтгэл 77,66 хувь) зарцуулан ажилласан байна. Үүнээс: Хорооны хуралдааны цагийн урамшуулал хөлс 190.53 сая төгрөг гишүүдийн байгууллагаас төлсөн НДШ, АО-ийн шимтгэлд 23.80 сая төгрөг, НДШ-д 14.50 сая төгрөг, ХХАОТ-д 17.60 сая төгрөг тус тус зарцуулсан болно.

Байгууллагын өр авлага барагдуулах ажлын хүрээнд 2023 оны жилийн эцсийн тайлангаар, ХХЗХ-ноос олгосон 1141 зөвшөөрлийн 4603.5 сая төгрөгийн тайлагнагдсан авлагаас 51% буюу 256 зөвшөөрлийн 2333.2 сая төгрөгийн авлага барагдуулсан.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийг шийдвэрлэсэн тайлангийн танилцуулга (Хорооны 2022 оны жилийн эцэс, 2023 оны 1 дүгээр улирал)-ыг сонсож, цаашид өргөдөл, гомдол хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх, дүн шинжилгээ хийж, мэдээллийн ил тод байдлыг хангах хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг холбогдох бүтцийн нэгжид даалгав.

Байгууллагын архив, бичиг хэргийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хөтлөх, зохион байгуулж, 2023 оны эцсийн байдлаар ХХЗХ-нд нийт 1764 утга бүхий албан бичгийг давхардсан тоогоор 7109 ААН, иргэнд боловсруулан явуулсан бөгөөд давхардсан тоогоор 1796 албан бичиг, өргөдөл гэрээ, тайлан мэдээг хүлээн авч шийдвэрлэв. Үүнээс: 700 нь цахимаар, 6409 нь шуудангаар хүргэгдсэн болно. Нийт 3010 аж ахуй нэгж, иргэнээс ирсэн бичгийг бүртгэл хяналтын картаар бүртгэж, цахим мэдээллийн (i.crc.gov.mn) системд бүртгэх ажлыг 100% гүйцэтгэсэн. ХХЗХ-ны 2023 оны хуралдааны тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, батлагдсан зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлагын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд холбогдох яам, байгууллага, дүүрэг, татварын алба, мэргэжлийн хяналтын газар,



ААН, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, хуулийн этгээд нарт 320 гаруй албан тоотой тус тус албажуулан хүргүүлэх арга хэмжээг авч ажиллав.

ХХЗХ-ны хэмжээнд 2023 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч, хуулийн этгээд, иргэд, хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийн тайлан мэдээллийг нэгтгэн, улирал бүр Зохицуулах хорооны хуралдаанд танилцуулан хольогдох удирдамж чиглэл авч ажилласнаар санал гомдолд дийлэнх хувийг эзэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд холбогдох албан тоот, санал зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, хамтран ажилласан болно. 2023 оны жилийн эцсийн байдлаар, тусгай зөвшөөрөл эзэмшигч, аж ахуй нэгж, харилцаа холбооны үйлчилгээний хэрэглэгчдээс Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжин 126, албан бичгээр 567, и-мэйл хаягаар, биечлэн, цахим системээр-64, утсаар 284 нийт 1041 өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авч бүртгэлийн санд төвлөрүүлэн 99,6%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллав. Зохицуулах хороонд ирсэн нийт өргөдөл, гомдол, санал хүсэлтийг чиглэл бүрээр ангилан үзүүлбэл: Үүнээс 45% нь цахим орчинтой холбоотой; 16,6% үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч; 13,7% олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч; 4,6% радио телевизийн үйлчилгээ эрхлэгч; 8,3% эрүүл ахуй харилцан нөлөөлөл; 5,8% хорооны эрхлэх асуудлыг хүрээнд; 2% нь интернэтийн үйлчилгээ эрхлэгч; 1,3% тусгай дугаарын тухай, 2,3% шуудангийн үйлчилгээ эрхлэгч; суурин холбооны үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой 0,4% гомдол санал тус тус эзэлсэн байна.

Байгууллагын архивд ХХЗХ-ны 2023 оны хуралдааны болон байгууллагын үйл ажиллагааны тайлан, 2023 онд Хорооны хуралдаанаар баталсан 177 тогтоол, 8 хуралдааны тэмдэглэл болон хуралдаанаас өгсөн удирдамж чиглэл, үүрэг даалгаврын тэмдэглэл протокол, биелэлтийг зохих журмын дагуу судалгаа тайлан ба архивын товчоог бүрдүүлж, хэрэгжилтийн тайлангийн хамт ЗУХАГ, архивд хүлээлгэн өгч цахим хэлбэрт шилжүүлсэн болно.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд ОУЦХБ (ITU), АНДЦХБ (АРТ), АНДШБ (АРПУ), Олон улсын харилцаа холбооны хүрээлэн (IIC) зэрэг олон улс бүс нутгийн олон улсын байгууллагын их хурал, уулзалт, семинар болон Тайланд, Сингапур, Малайз улсын зохицуулах байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, урт ба богино хугацааны сургалтад хамрагдах, туршлага судлан хамтарсан уулзалт, семинарт давхардсан тоогоор байгууллагын 23 тооны удирдлага, албан хаагч, ажилтан нарыг хамруулав. Үүнд: Өргөн нэвтрүүлгийн чуулга уулзалт, Дэлхийн радио их хуралд бэлтгэх бүсийн семинар; Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага (ОУЦХБ)-ын Зохицуулагчдын их хурал, Дэлхийн радиогийн Ассамблейн чуулга, Их хурал (WRS-2023); Ази, номхон далайн цахилгаан холбооны байгууллагын Ерөнхий Ассамблейн 16 дугаар чуулган; Ази, номхон далайн цахилгаан холбооны байгууллагын Удирдлагын хорооны ээлжит 47 дугаар хуралдаан (47-th Session of the Management Committee, АРТ); Ази, номхон далайн шуудангийн байгууллагын гүйцэтгэх зөвлөлийн хурал; Олон улсын харилцаа холбооны хүрээлэн (IIC)-ийн чуулга уулзалт, олон улсын зохицуулах байгууллагын семинар г.м.



Ажлын хэсгээс боловсруулсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон орлого, зардлын төлөвлөгөө, байгууллагын 2025-2026 оны төсвийн төсөөлөл”-ийг Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 15 дугаар хуралдаан, ээлжит 16 дугаар хуралдаанд тус тус хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв. ХХЗХ-ны 2023 оны ээлжит 16 дугаар хуралдаанаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө (Нийтдээ 2024 оны төлөвлөгөөнд үндсэн 3 ангиллын бүтээгдэхүүний 293 ажил, үйл ажиллагаа төлөвлөгдсөнөөс Хорооны үйл ажиллагааны 2022-2025 оны дунд хугацааны стратегийн зорилго, зорилтод чиглэсэн 32 бүтээгдэхүүний 131 үйл ажиллагаа, нийтлэг ажил үйлчилгээ болон хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх 52 чиглэлийн бүтээгдэхүүний 121 үйл ажиллагаа, дотоод үйл ажиллагааны бүтээгдэхүүний 13 чиглэлийн 56 ажлууд багтаасан)-ний төсөл, 2024 оны орлого зардлын төлөвлөгөө, байгууллагын 2025-2026 оны төсвийн төсөөллийг батлах тухай” тухай танилцуулга, тогтоолын төсөл, хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр, төсөв тооцоо, орлого зардлын тооцоо судалгаа, төлөвлөгөөний төсөл, тогтоолын хавсралтууд болох “Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл “ХХЗХ-ны 2024 оны орлогын төлөвлөгөө”-ний төсөл, “ХХЗХ-ны 2024 оны зардлын төлөвлөгөө”-ний төсөл, “ХХЗХ-ны 2024 оны хөрөнгө оруулалтын зардал”-ын төсөл, “ХХЗХ-ны 2024 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ын төсөл, “ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны зардал”-ын төсөл, “ХХЗХ-ны 2025-2026 оны төсвийн төсөөлөл”-ийн төслийг тус тус авч хэлэлцсэн ба тус хуралдаанаар Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дах заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолоор баталсан, Засгийн газрын 2020 оны 65 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4.3.2 дах заалтыг тус тус үндэслэн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 155 тоот “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, 2025-2026 оны төсвийн төсөөлөл”-ийг батлах тухай” тогтоолыг 7 хавсралтын хамт батлав. Энэхүү тогтоолын хавсралтаар (Тогтоол-155: Хавсралт-1: “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”; Хавсралт-2: “ХХЗХ-ны 2024 оны орлогын төлөвлөгөө”; Хавсралт-3: “ХХЗХ-ны 2024 оны зардлын төлөвлөгөө”; Хавсралт-4: “ХХЗХ-ны 2024 оны хөрөнгө оруулалтын зардал”; Хавсралт-5: “ХХЗХ-ны 2024 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”; Хавсралт-6: “ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны зардал”; Хавсралт-7: “ХХЗХ-ны 2025-2026 оны төсвийн төсөөлөл”) баталсан Хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, батлагдсан зардал, төсвийг зориулалтын дагуу зарцуулан тухай бүр гүйцэтгэлийг тайлагнан ажиллахыг Хорооны дарга /Г.Чинзориг/-д даалгав.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Орон тооны бус гишүүнээс төлөөлөх тухай” 210 тоот захирамжаар Харилцаа холбооны тухай хуулийн 8.3-т заасныг үндэслэн Өлзийбаяр овогтой Золбаярыг тус Хорооны орон тооны бус гишүүнээс чөлөөлөв.



Хорооны хуралдаанаар батлагдсан тогтоол, тогтоолын хавсралтуудыг тусгай фолдерт байршуулан албан болон дотоод хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлэн ажилласан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зарлагын төсөв, хорооны хуралдааны тогтоол шийдвэр, хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг зохион байгуулж, Даргын зөвлөл болон Зохицуулах хорооны хуралдаанд танилцуулах, хэлэлцүүлэх, хуралдааны тэмдэглэлээр өгсөн удирдамж, үүрэг даалгаврыг холбогдох бүтцийн нэгжийн дарга нарт хүргүүлж мэдэгдэх, биелэлтийн тайланг хорооны хуралдаан бүрээр нэгтгэн гаргаж, тухай бүр удирдлагад танилцуулан Дотоод хяналт, аудитын албанаас шинжилгээ, үнэлгээг хийж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан болно.

“Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023-2025 оны үйл ажиллагааны стратеги”-ын зорилго зорилт, төлөвлөлтийг байгууллагын жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган баталснаар хууль эрх зүйн хэрэгжилтийг зөв, зохистой аргаар түргэн шуурхай хангуулахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай гол нөөцийг үр ашигтай удирдах, төлөвлөлтийг оновчтой болгох, гүйцэтгэлийн үнэлгээний системийг сайжруулах зэрэг Зохицуулах хорооны дотоод хэрэгцээ, шаардлагыг хангах чухал ач холбогдолтой юм. Энэхүү баримт бичгийг хэрэгжүүлэхийн тулд жил бүр системтэйгээр төлөвлөж, оролцогч талуудын харилцаа, хүний болон бусад шаардлагатай нөөцийг стратеги суурьтай удирдаж, жил бүрийн гүйцэтгэлийг бодитой тайлагнаж ажиллах, зорилтууд хангагдахын хэрээр зах зээл өсөн тэлж, Харилцаа холбоо мэдээллийн технологийн салбарын хөгжил нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тулгуур болно гэж үзэж байна.

ТАНИЛЦСАН:

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ

2024-01-05



**ХАВСРАЛТ-1**

**ХОРООНЫ ХУРАЛДААНААР ШИЙДВЭРЛЭСЭН  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
СУДАЛГАА  
(2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР)**

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХУРАЛДААНААР ШИЙДВЭРЛЭСЭН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
СУДАЛГАА**  
(2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР)

д/д	Тогтоолын дугаар	Тогтоолын огноо	Шинээр олгосон		Хугацаа сунгасан		Сэргээсэн		Өөрчлөлт оруулсан		Түдгэлзүүлсэн		Хүчингүй болгосон		Шилжүүлэх	
			Хуулийн этгээд	Т3-ийн тоо	Хуулийн этгээд	Т3-ийн тоо	Хуулийн этгээд	Т3-ийн тоо	Хуулийн этгээд	Т3-ийн тоо	Хуулийн этгээд	Т3-ийн тоо	Хуулийн этгээд	Т3-ийн тоо	Хуулийн этгээд	Т3-ийн тоо
1	5	2023.01.31	13	15												
2	6	2023.01.31				10	13									
3	7	2023.01.31							1	1						
4	8	2023.01.31							2	2						
5	9	2023.01.31													1	2
6	10	2023.01.31			22	26										
7	11	2023.01.31												1	2	
8	12	2023.01.31												2	2	
9	13	2023.01.31												7	7	
10	18	2023.02.17	8	8												
11	19	2023.02.17			9	9										
12	20	2023.02.17														
13	21	2023.02.17							2	3						
14	25	2023.03.17	5	5											2	4
15	26	2023.03.17														
16	27	2023.03.17			5	6		5								
17	28	2023.03.17										5	7			
18	29	2023.03.17														
19	31	2023.03.30	4	4										2	3	
20	32	2023.03.30			8	13										
21	33	2023.03.30														
22	34	2023.03.30							1	1					1	1
23	36	2023.04.21	4	4												
24	37	2023.04.21						2		2						





95	139	2023.11.10										1	3						
96	140	2023.11.10																1	2
97	146	2023.11.30	7	7															
98	147	2023.11.30			1	1													
99	148	2023.11.30										1		1					
100	149	2023.11.30										14		21					
101	150	2023.11.30															1	1	
102	153	2023.12.06			7	7													
103	154	2023.12.06															1	1	
104	156	2023.12.20	7	8															
105	157	2023.12.20				4	7												
106	158	2023.12.20										1	1						
107	159	2023.12.20															1	2	
108	160	2023.12.20														1	1	1	
109	164	2023.12.20	1	2															
110	165	2023.12.20	1	2															
111	166	2023.12.20	1	2															
112	167	2023.12.20	1	2															
113	168	2023.12.20	1	2															
114	169	2023.12.20	1	2															
115	170	2023.12.20	1	2															
116	171	2023.12.20	1	2															
117	172	2023.12.20	1	2															
118	173	2023.12.20	1	2															
119	174	2023.12.20	1	2															
120	175	2023.12.20	1	2															
121	176	2023.12.20	1	2															
122	177	2023.12.20	1	2															
			<b>НИИТ</b>			<b>92</b>	<b>97</b>	<b>128</b>	<b>154</b>	<b>48</b>	<b>60</b>	<b>13</b>	<b>19</b>	<b>54</b>	<b>74</b>	<b>69</b>	<b>86</b>	<b>3</b>	<b>6</b>



**ХАВСРАЛТ-2**

**ХОРООНЫ ХУРАЛДААНААР 2023 ОНД БАТАЛСАН  
ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТ  
(2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР)**



**ХОРООНЫ ХУРАЛДААНААР 2023 ОНД БАТАЛСАН  
ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТ  
(2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР)**

№	Хорооны баталсан тогтоол, тэмдэглэлийн дугаар	Огноо	Тогтоол, тэмдэглэлийн товч агуулга	Хэрэгжилтийн байдал
<b>Нэг. Хорооны хуралдааны тогтоол</b>				
1	Тогтоол 01	2023.01.31	"Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №5060: Хорооны 2021 оны 02 тоот тогтоол)	ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2023 оны 01/169 албан тоотор хүргүүлэв. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5060 дугаарт бүртгэлтэй 2021 оны 02 тоот тогтоолд оруулсан 2023 оны 01 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн болно.
2	Тогтоол 02	2023.01.31	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай (ХЗДХЯ №4904: Хорооны 2020 оны 64 тоот тогтоол)	ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон (Хорооны 2020 оны 64 тоот тогтоол) шийдвэрийн 4904 тоот улсын бүртгэлээс 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр хассан болно.
3	Тогтоол 03	2023.01.31	Үйлчилгээний тариф батлах тухай (Юнивишн ХХК)	Энэхүү тогтоолоор Юнивишн ХХК-ийн үйлчилгээний тарифыг хавсралтад заасны дагуу тогтоож баталж, батлагдсан тарифын дагуу үйлчилгээний тарифыг тогтоож, хэрэглэгчдэд сурталчлах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэн ажиллахыг Юнивишн ХХК-д зөвшөөрөв. Уг тогтоол, тогтоож баталсан тарифыг тус компанийн удирдлагад албан ёсоор хүргүүлж, хамтран ажиллаж байна.
4	Тогтоол 04	2023.01.31	Үйлчилгээний тариф батлах тухай (ДДэш ТВ ХК)	Батлагдсан тарифын дагуу үйлчилгээний тарифыг тогтоож, хэрэглэгчдэд сурталчлах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэн ажиллахыг ДДэш ТВ ХХК-д зөвшөөрөв. Уг тогтоол, тогтоож баталсан тарифыг тус компанийн



				удирдлагад албан ёсоор хүргүүлж, хамтран ажиллаж байна.
5	Тогтоол 05	2023.01.31	Тусгай зөвшөөрөл олгох тухай	ТЗ шинээр олгосон: 13 хуулийн этгээдэд 13 тусгай зөвшөөрөл (2023-02-02, 07/128)
6	Тогтоол 06	2023.01.31	Тусгай зөвшөөрөл сэргээх тухай	ТЗ хүчингүй сэргээсэн: 10 хуулийн этгээдийн 10 тусгай зөвшөөрөл (2023-02-02, 07/127)
7	Тогтоол 07	2023.01.31	Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай	ТЗ нэмэлт өөрчлөлт оруулсан: 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөл
8	Тогтоол 08	2023.01.31	Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай (РД)	ТЗ нэмэлт өөрчлөлт оруулсан: 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөл (2023-02-02, 07/132)
9	Тогтоол 09	2023.01.31	Тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай	Тусгай зөвшөөрөл шилжүүлсэн: 1 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөл
10	Тогтоол 10	2023.01.31	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай	Тусгай зөвшөөрөл сунгасан: 22 хуулийн этгээдийн 23 тусгай зөвшөөрөл (2023-02-02, 07/130)
11	Тогтоол 11	2023.01.31	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай	ТЗ хүчингүй болгосон: 1 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөл
12	Тогтоол 12	2023.01.31	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай (РД)	ТЗ хүчингүй болгосон: 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөл (2023-02-02, 07/133)
13	Тогтоол 13	2023.01.31	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай (ӨН)	ТЗ хүчингүй болгосон: 7 хуулийн этгээдийн 7 тусгай зөвшөөрөл (2023-02-02, 07/129)
14	Тогтоол 14	2023.01.31	"Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-д өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №4970: Хорооны 2020 оны 88 тоот тогтоол)	ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан өөрчлөлтийг нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2023 оны 01/169 албан тоотой хүргүүлэв. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4970 дугаарт бүртгэлтэй 2020 оны 88 тоот тогтоолд оруулсан 2023 оны 14 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан өөрчлөлтийг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн болно.
15	Тогтоол 15	2023.01.31	"Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл,	ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан өөрчлөлтийг бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2023 оны 01/169 албан



			шаардлага"-д өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №5305: 2021 оны 23 тоот тогтоол)	тоотоор хүргүүлэв. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5305 дугаарт бүртгэлтэй 2021 оны 23 тоот тогтоолд оруулсан 2023 оны 15 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан өөрчлөлтийг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн болно.
16	Тогтоол 16	2023.01.31	"Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-д өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №5306: Хорооны 2021 оны 24 тоот тогтоол)	ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан өөрчлөлтийг нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2023 оны 01/169 албан тоотоор хүргүүлэв. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5306 бүртгэлтэй 2021 оны 24 тоот тогтоолд оруулсан 2023 оны 16 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан өөрчлөлтийг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн болно.
17	Тогтоол 17	2023.02.17	Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасаж, актлах саналын тухай	ТӨБЗГ-т Даргын 2023 оны ..... албан тоотоор хүргүүлэв.
18	Тогтоол 18	2023.02.17	Тусгай зөвшөөрөл олгох тухай	ТЗ шинээр олгосон: 8 хуулийн этгээдэд 8 тусгай зөвшөөрөл (2023-03-01, 07/260)
19	Тогтоол 19	2023.02.17	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай	Тусгай зөвшөөрөл сунгасан: 9 хуулийн этгээдийн 9 тусгай зөвшөөрөл (2023-03-01, 07/261)
20	Тогтоол 20	2023.02.17	Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	ТЗ нэмэлт өөрчлөлт оруулсан: 2 хуулийн этгээдийн 3 тусгай зөвшөөрөл (2023-03-01, 07/262)
21	Тогтоол 21	2023.02.17	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай	ТЗ хүчингүй болгосон: 2 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрөл (2023-03-01, 07/263)
22	Тогтоол 22	2023.02.28	"Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлага" батлах тухай /Шуудангийн сүлжээ байгуулах/ (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №6233)	ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан шинээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2023 оны 01/281 албан тоотоор хүргүүлэв. ХЗДХЯ-ны санал, зөвлөмжийг ХХЗХ-ны ээлжит 05 дугаар хуралдаанаар авч хэлэлцээд редакцын засвар оруулав. ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн 6233 тоот улсын бүртгэлд 2023 оны



				05 дугаар сарын 23-ны өдөр шинээр бүртгүүлэн баталгаажуулсан. Хүчингүй болгосон: 2019 оны 52 тоот тогтоол
23	Тогтоол 23	2023.02.28	"Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг батлах тухай (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №6194)	ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан шинээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2023 оны 01/281 албан тоотоор хүргүүлэв. ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн 6194 тоот улсын бүртгэлд 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр шинээр бүртгүүлэн баталгаажуулсан. Бүртгүүлсэн тогтоолыг хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем ( <a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a> ), хорооны цахим хуудас ( <a href="http://www.crc.gov.mn">www.crc.gov.mn</a> )-д тус тус байршуулсан. Хүчингүй болгосон: 2019 оны 53 тоот тогтоол
24	Тогтоол 24	2023.02.28	"Шуудангийн харилцан холболтын журам"-д өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №4696; Хорооны 2019 оны 54 тоот тогтоол)	ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан өөрчлөлтийг бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2023 оны 01/281 албан тоотоор хүргүүлж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4696 бүртгэлтэй 2019 оны 54 тоот тогтоолд оруулсан 2023 оны 24 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан өөрчлөлтийг 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн болно.
25	Тогтоол 25	2023.03.17	Тусгай зөвшөөрөл олгох тухай	ТЗ шинээр олгосон: 5 хуулийн этгээдэд 5 тусгай зөвшөөрөл (2023-03-20, 07/353)
26	Тогтоол 26	2023.03.17	Тусгай зөвшөөрөл сэргээх тухай	Тусгай зөвшөөрөл сэргээсэн: 9 хуулийн этгээдийн 9 тусгай зөвшөөрөл (2023-03-20, 07/354)
27	Тогтоол 27	2023.03.17	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай	Тусгай зөвшөөрөл сунгасан: 9 хуулийн этгээдийн 9 тусгай зөвшөөрөл (2023-03-20, 07/355)
28	Тогтоол 28	2023.03.17	Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай	ТЗ түдгэлзүүлсэн: 45 хоног 2 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрөл (2023-03-20, 07/356)



29	Тогтоол 29	2023.03.17	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай	ТЗ хүчингүй болгосон: 2 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрөл (2023-03-20, 07/357)
30	Тогтоол 30	2023.03.30	"Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ №5306: Хорооны 2021 оны 74 тоот тогтоол)	ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2023 оны 01/444 албан тоотор хүргүүлэв. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5306 бүртгэлтэй 2021 оны 74 тоот тогтоолд оруулсан 2023 оны 30 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2023 оны 04 дугаар сарын 23-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн болно.
31	Тогтоол 31	2023.03.30	Тусгай зөвшөөрөл олгох тухай	ТЗ шинээр олгосон: 4 хуулийн этгээдэд 4 тусгай зөвшөөрөл (2023-04-03, 07/407)
32	Тогтоол 32	2023.03.30	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай	Тусгай зөвшөөрөл сунгасан: 8 хуулийн этгээдийн 13 тусгай зөвшөөрөл (2023-04-03, 07/410)
